

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн байршил	3
1.2. Ордын уул техникийн нөхцөл	4
1.3. Ашиглалтын технологи	4
1.4. Ил уурхайн үндсэн хэмжээс	5
1.5. Уулын ажлын календарчилсан төлөвлөлт	5
1.6. Ил уурхайн процесс, үндсэн болон туслах тоног төхөөрөмж	5
БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал	8
3.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал	8
3.3. Усны чанарт нөлөөлөх байдал	8
3.4. Хөрсний чанарт нөлөөлөх байдал	8
3.5. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал	8
3.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал	9
БҮЛЭГ-4. “ГУРВАН САЛАА” ЭЛС, ХАЙРГАНЫ УУРХАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	10
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	22
4.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл	23
ДҮГНЭЛТ	24
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-43000321 тоот тусгай зөвшөөрлийн талбайн мэдээллүүд	4
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	14
Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг	3
---	---


БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“ЗУУБ” ХХК нь 2015.02.12 онд байгуулагдсан бөгөөд Монгол улсын 1311011146 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуй нэгжийн гэрчилгээтэй.

“ЗУУБ” ХХК нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших 32.12 га талбай бүхий “Гурван салаа” элс хайрганы ордын MV-43000321 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр авсан бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2038 он хүртэл хүчинтэй.

1.1. Төслийн байршил

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Гурван салаа” нэртэй талбай нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт Улаанбаатар хотоос 175 км орчимд, Мандал сумын төвөөс БУ 5 орчим км-т Хараа голын хойд дэнж, хөвөөний өндөр татам дээр оршино.



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

Ашигт малтмал ашиглалтын MV-43000321 дугаар бүхий тусгай зөвшөөрөлтэй “Гурван салаа” нэртэй талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000 масштабтай байр зүйн зургийн М-48-117 нэрлэвэртэй хавтгайд байрлана.

Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээ зэрэг мэдээллүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. MV-43000321 тоот тусгай зөвшөөрлийн талбайн мэдээллүүд

Талбайн нэр	Талбайн булангийн эргэлтийн цэгийн солбилцол (WGS-84 эллипсоидод)		Тэгш өнцгийн солбицол (UTM тусгалд)		Талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрөл олгосон
	Өргөрөг	Уртраг	X	Y		
“Гурван салаа” элс, хайрганы орд	1. 106° 25' 22.44"	48° 49' 37.64"	603663.60	5409200.25	32.11	2023.06.12
	2. 106° 25' 22.36"	48° 49' 48.03"	604432.80	5409214.27		
	3. 106° 24' 58.65"	48° 49' 48.01"	604425.17	5409535.05		
	4. 106° 24' 58.39"	48° 49' 56.64"	603941.84	5409525.41		
	5. 106° 24' 44.71"	48° 49' 56.64"	603931.58	5409791.79		
	6. 106° 24' 44.71"	48° 49' 37.65"	603652.72	5409786.60		

БОАЖЯ-ны цахим ой, ус тусгай хамгаалалттай газар нутгийн кадастрын давхцалгүй бөгөөд лавалгаа мэдээллийг хавсралтаар оруулсан. Ашиглалтын талбай нь “Хараа” голын хөндий өндөр татамд байрлах ба хуулиар тогтоогдсон энгийн хамгаалалтын бүсээс 500м зайтай оршдог.

1.2. Ордын уул техникийн нөхцөл

Төсөл хэрэгжүүлэгч “ЗУУБ” ХХК –ийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших “Гурван салаа” элс хайрганы ордын нөөц нь УГА-ны даргын 2023 оны 02-р сарын 24-ны өдрийн Н/11 тоот тушаалаар батлагдсан ба баттай А зэрэглэлийн 360,510 м3, бодитой В зэрэглэлийн нөөц 545,681 м3, боломжтой С зэрэглэлийн нөөц 787,180 м3, нийт А+В+С зэрэглэлийн 1,693,370 м3 байна. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж-III /Элс хайрга/-ийн дагуу I бүлгийн ордод хамаарах тул ил уурхайн ашиглалтыг зөвхөн баттай ба бодитой А+В зэрэглэлийн геологийн 906.19 мян.м3 нөөцөд тулгуурлан тооцоолсон.

Ашиглалт явуулах 32.12 га талбайд элс хайрганы нөөц нь жигд тархацтай, ордын геологийн тогтоцын хувьд тэгшивтэр гадаргуутай нэг давхарга бүхий харьцангуй тогтвортой энгийн тогтоцтой ба хөрсний дундаж зузаан нь 1 м, ашигт малтмалын дундаж зузаан 4.5 м, үүсэх ил уурхайн хамгийн гүн хэсэгтээ 6.0 м хүрэх ба дундаж гүн 5.5 м-с ихгүй байхаар онцлогтой юм.

Ордын хэмжээнд уст үе 2.0 м-ээс илэрсэн ба ил уурхайд орж ирэх усан хангамж харьцангуй их тул ил аргаар хөвөгч драг ашиглан ус хөлдөх хүртэл улиралын чанартай олборлолт явуулахад уул техникийн нөхцлийн хувьд хүндрэлгүй.

1.3. Ашиглалтын технологи

Тус ордыг драг ашиглан олборлох ба давхарга, хөрсний зузаан зэргийг харгалзан, мөн гүнрүүгээ нөөц нэмэгдэх боломжтой гэж үзэж авто тээвэр бүхий гадаад овоолготой ашиглалтын технологиор ашиглахаар төслийн шийдлийг гаргасан. Элс хайрганы ордын тогтоц нь ил аргаар олборлолт явуулахад хялбар, хөрсний тээвэрлэлтийн зайг богино байлгах, өгсүүр налуу гадаргуй байхгүй тээвэрлэлт хийхэд хүндрэлгүй зэрэг давуу талтай.

1.4. Ил уурхайн үндсэн хэмжээс

Доголын өндөр: Ил уурхайн доголын өндрийг $H_d=6$ м байхаар тооцсон. Энэ нь ажиллах драгын техникийн параметрт уялдуулан тооцоолсон хэмжээ юм. Драгаар олборлох үеийн процесст ажлын бус доголын өндөр нь $H_d=6$ м байх ба 1 м түвшинд хөрс хуулалтын ажлыг экскаватор гүйцэтгэх ба 5 м түвшингийн олборлолтын ажлыг драгаар гүйцэтгэх тул дан доголоор үүсгэх ахилт явагдах байдлаар давшина. Ил уурхайн бүсэд үүсэх замын уртыг багасгах замаар уурхайн хүрээний тээврийн зардлыг хэмнэх нөхцөл бүрдэх болно.

Доголын хажуугийн өнцөг: Ил уурхайн хажуугийн налуугийн өнцгийг тооцохдоо “Грапроруда”-ийн баримтлалтын дагуу чулуулгийн бат бөхийн тодорхойлолт зөөлөндүү ба зөөлөн чулуулаг, шороо бат бөхийн коэффициент 0.6-1 хүртэлх ангилалаар тооцсон. Ил уурхайн гүн хамгийн ихдээ 6.0 м хүрэх ба дундаж нь 5.5 м харьцангуй бага гүнтэй учир ажлын доголын хажуугийн өнцөг $\alpha_d=55^\circ$ байхад тогтвортой гэж үзэн сонгож авсан.

Ажлын талбайн өргөн: Ил уурхайд ажиллах экскаватор болон автосамосвалын техникийн үзүүлэлтүүдээс шалтгаалан ил уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн 20 м- ээс багагүй байна. Харин олборлогч драгын орлын өргөн ахилтын фронтын дагуу чөлөөтэй ажил явагдах орон зайн орлын өргөн 20 м-с багагүй байна.

Уурхайн замын өргөн: Уурхайн замын өргөнийг тухайн замаар явах тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааруулан бага байлгах үүднээс 8 м байхаар тооцсон.

1.5. Уулын ажлын календарчилсан төлөвлөлт

“Гурван салаа” элс хайрганы ордын олборлолт нь нийт 20 жил үргэлжлэх ба ашиглалтын эхний жил буюу 2025 онд нийт 10.4 мян.м³ хөрс хуулж 30 мян.м³ ашигт малтмал олборлож 40.4 мян.м³. уулын цул олборлолтонд өртөнө. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.2 м³/м³ байна.

1.6. Ил уурхайн процесс, үндсэн болон туслах тоног төхөөрөмж

Ил уурхайн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэгчийн ажлын даалгаварт тусгасны дагуу одоо ашиглаж байгаа техникуудийг үргэлжлүүлэн ашиглахаар тусгаж тооцсон болно.

Уурхайн хөрс хуулалтын ажилд Hyundai-LC300 1 ш, элс, хайрга олборлолтын ажилд JSD-200 драг 1 ш, хөрс, ашигт малтмал тээвэрлэлтийн ажилд BIEBEN-ND3250 25тн даацтай автосамосвал 3 ш, шимт хөрс хуулалтанд SHANTUI-SD23 бульдозерь 1 ш, ангилан ялгах үйлдвэрийг тэжээлээр хангах болон туслах ажилд LIUGONG-ZL50 маркийн 3 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч 1 ш тус тус ашиглана.

Ашиглалтын 2025 оны хугацаанд нийт 10.4 мян.м³ хөрс хуулж 30 мян.м³ ашигт малтмал олборлож 40.4 мян.м³. уулын цул олборлолтонд өртөнө. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.2 м³/м³ байна.

БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Уг талбай нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн нурууны уулархаг мужуудын ой, ойт хээрийн бүсэд хамаарна. Гадаргуугийн хувьд элэгдэлд орсон дунд өндөртэй уулс зонхилох ба үнэмлэхүй өндөр нь 800-1400 м-т хэлбэлздэг, 200-300 м-ийн харьцангуй өндөртэй. Уулс нь ихэвчлэн бөмбөгөр оройтой, налуу хажуутай байх нь элбэг.

Хараа голын хөндий нь нэлээд өргөн бөгөөд томоохон тэвш хэлбэртэй тэгшивтэр гадаргуутай аллювийн хөндийгөөс дээшлэхэд налуувтар гадаргууд шилжиж пролювийн дэнж үүсгэнэ. Гадаргуугийн гарш илэрцийн хувьд дунд зэргийн төлөв байдалтай. Чулуулгийн үндсэн гарш уул, толгодын орой, хажуу хэсгээр голдуу тохиолдоно.

Ус зүй: Районы хэмжээнд усан сүлжээ нийлээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Хараа гол юм. Мөн Орхироо, Дарьт, Ноён зэрэг жижиг голууд байдаг бөгөөд эдгээр голууд нь Мандал сумын орчмоор Хараа голд цутгадаг.

Хараа гол нь Улаанбаатар хотын баруун хойно орших Хүйн голоос эх авч урсана. Голын урт 291 км, ус хуралдуулах талбай 15000 хавтгай дөрвөлжин км юм.

Хараа голд Бага Хэнтийн нуруунаас эх авсан Сөгнөгөр, Түнхэл, Баян зэрэг голууд цутгах учир голын өргөн, гүн нь адаг руугаа нэмэгдэж, хөндий нь уужирна. 7-9 дүгээр сард хур борооны үерийн долгион ажиглагдах ба 9 дүгээр сарын дундаас хойш усны түвшин эрс буурч өвлийн үед шилжинэ. 10 дугаар сарын сүүлээр хөлдөж жилийн 146-162 хоног зузаан мөсөөр хучаастай байна. Хүн малын унд, ахуйн хэрэгцээнд булаг шандын усыг хэрэглэх ба төв суурин газруудад голчлон гүний худгууд гаргасан байна.

Уур амьсгал: Тус нутаг нь өвөлдөө бага зэргийн цастай хүйтэн, зундаа бороотой халуун байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жингийн дундаж хэм -1.9°C -д хүрэх бөгөөд хамгийн хүйтэн 1 сард -37°C болж, хамгийн дулаан 7-р сард 35°C хүрнэ. Жилд унах хур тунадас дунджаар 244 мм байдаг.

Жилийн 4 улиралд хур тунадас харилцан адилгүй байх боловч 7, 8-р сард хур бороо зүсэрч олон хоногоор орно. Цас 10-р сараас эхлэн 3-р сар дуустал орох ба цасан бүрхүүлийн дундаж зузаан 0.5 мм хүрнэ. Салхины чиглэл хойд талаасаа зонхилох ба дунджаар 3.5 м/сек хурдтай боловч, 3-5-р сард 20-24 м/сек хүртэл шороон шуурга болдог.

Хөрс, ургамал: Хөрсний хувьд Хангайн хөрсний их мужийн хээрийн хүрэн хөрсний бүсэд багтдаг. Хур тунадас нь голдуу зун, намрын сард унах ба түр зуурын хүчтэй бороо, мөндөр, үерийн усаар хөрс нэлээд эвдэрч, идэгдсэн байдаг.

Дүүргийн хэмжээнд хөнгөн шавранцар, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хүрэн хөрс зонхилно. Хүрэн хөрсний хөрс үүсгэгч чулуулаг бусад байгалийн бүсийн хөрсний адил голдуу карбонатлаг хурдас дээр үүссэн гол төлөв сулавтар хүчиллэгээс шүлтлэг байдаг.

Нийт нутаг нь янз бүрийн төрлийн цэцэгт ба өвслөг ургамлаар бүрэн бүрхэгдсэн, уулын ар хажууд нарс, хусан ой, багаар улиангар голын хөндийд бургас, ховроор хус, нарс, улиас, монос зэрэг шилмүүст ба навчит модлог ургамал ургана.

Амьтны аймаг: Судалгааны талбайн районд мэрэгчдээс өмхий хүрэн, оготно, зурам, үхэр огодой, хэрэм, тарвага, махчин амьтдаас баавгай, үнэг, чоно, хярс, өвсөн тэжээлтнээс туулай, бор гөрөөс, буга, гахай, хэвлээр явагчдаас гүрвэл могой, шавьж идэштнээс зараа, жигүүртнээс шаазгай, харцага, болжмор, бүргэд, сар, элээ, хэрээ, тас, усны шувуудаас галуу, тогоруу, ангир, усны амьтдаас Хараа голд цурхай, зэвэг, хайруус, алгана, гутаарь, цулбуурт, булуу цагаан, улаан сүүлт, мөрөг зэрэг олон зүйл загас бий.

Дэд бүтэц, зам харилцаа: Талбайн хэмжээнд орших томоохон суурин газар нь Сэлэнгэ аймгийн Мандал сум. Тус сум нь 9-н багтай, үүнээс 2 нь тосгоны статустай. Нийт 7238 өрхөд 52562 мянган хүн ам ажиллаж амьдарч байна.

Монгол улсын хэмжээнд аймгийн төвөөс алслагдсан сумдаас хүн амын тоогоороо 1-рт ордог бөгөөд нэг хавтгай дөрвөлжин км-т 5.6 хүн оногдож байна. Улаанбаатар хотоос 175 км, Сэлэнгэ аймгийн төвөөс 210 км зайд байрладаг.

Мандал сум нь Улаанбаатар хоттой төмөр зам болон засмал зам, холбоо харилцааны ба өндөр хүчдлийн шугамаар холбогдсон. Нутгийн аль ч хэсэгт жилийн 4-н улиралд автомашинаар явах бүрэн бололцоотой. Энэ бүхэн нь тус хайгуулын талбай нь Дархан-Сэлэнгийн газарзүй-эдийн засгийн үйлдвэрлэл хөгжиж буй тааламжтай цогцолбор дэд бүтцийн нутагт оршиж байгааг харуулна.

Тус сумын цахилгаан хангамжийн эх үүсвэр нь Төвийн эрчим хүчний системийн шугамаас Төвийн бүсийн ЦД Сүлжээ ХК-ны Дархан-Сэлэнгийн салбарын Зүүнхараа дэд өртөө авч дамжуулдаг. 2 талын тэжээлтэй 110/35/6 кв-ын хүчдэлтэй 2 x 10000 квт чадалтай дэд өртөөний хуваарилах байгууламжаас 10 фидэр гарч Зүүн хараа болон Хэрх тосгоныг 6/0.4 кв-ын, Түнхэл тосгоныг 35/10 кв-ын дэд өртөөгөөр дамжуулан ЦЭХ-ээр тус тус хангагддаг.

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон угаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Элс, хайраг олборлох уурхайд:

- ✓ Хөрс хуулах, элс, хайрга олборлох үед тоос үүсэх,
- ✓ Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,
- ✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,
- ✓ Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,
- ✓ Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

3.2. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Элс, хайрга олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

3.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

3.4. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

3.5. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдлоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

3.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

БҮЛЭГ-4. “ГУРВАН САЛАА” ЭЛС, ХАЙРГАНЫ УУРХАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: “ЗУУБ” ХХК-ийн “Гурван салаа” нэртэй элс, хайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

“Гурван салаа” элс, хайрганы уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **8,600,000.0** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвчид төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- ✓ Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- ✓ БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- ✓ Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- ✓ БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалаллын ажил хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Гурван салаа” нэртэй элс, хайрганы ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	- Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох	Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг усалгаа хийх, тусгай сатериал тороор хучих, ургамалжуулах зэргээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Шимт хөрсний овоолго, Уурхайн дотоод зам	-	Дотоод төсөв			Тогтмол	- Агаарын тухай хууль, - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007,
Гадаргын ус									
2	Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх	-Голын эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоох, хамгаалалтын байгууламжийг сэргээх - Модоор хамгаалалтын зурвас байгуулах, - Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах	Төслийн хүрээнд	-	500.0	1	500.0	Тогтмол	- Усны тухай хууль, - Гадаргын усны чанарыг хянах журам MNS 4047- 88

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ГУРВАН САЛАА” НЭРТЭЙ ЭЛС, ХАЙРГАНЫ УУРХАЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-43000321

Хөрсөн бүрхэвч									
1	- Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шим, чийг буурах, бохирдох, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах	Шимт хөрсний овоолго	-	Үйл ажиллагааны зардалд орсон.			Тогтмол	- БОХ. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS 3985- 87
3		Уурхайд олон салаа зам гаргахгүй байх, таних тэмдэг байршуулах, сайжруулах	Зам талбай		Дотоод төлөвлөлтөөр			Үйл ажиллагааны эхэн үед	
5		Хог хаягдлаар уурхайн орчин бохирдохоос сэргийлэх	Уурхайн орчин	-	100.0	-	100.0	Тогтмол	
Ургамлан нөмрөг									
1	Уурхайн үйл ажиллагаанаас ургамлын бүрхэвч доройтох	Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу байгуулах, хамгаалах, унаган ургамлын үрийг түүх, хатаах, хадгалах	Уурхайн талбайд	Нөхөн сэргээллтэй цуг хийгдэнэ					MNS 5918:2008
Амьтны аймаг									
	Уурхайн ухаш болон уурхайн талбайд амьтан нэвтрэхээс хамгаалах	Уурхайн овоолго болон ухашийн гадуур хамгаалалтын хайс, тор татах	Уурхайн талбай	-	2'000.0	-	2'000.0	-	Амьтны тухай хууль
-		Нийт дүн			-		2'600.0		

4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Одоогийн байдлаар уурхайн карьер гүн рүүгээ олборлож байгаа тул нөхөн сэргээлтийн төлөвлөгөө байхгүй. Харин “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2025 онд 100 ширхэг мод тарих ба 1'125.0 мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөө.

4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих үеэр тус уурхайн орчимд биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээ хийх, гарсан үр дүнд тулгуурлан биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгааллын стратеги боловсруулж Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын холбогдох мэргэжилтнүүдэд албан ёсоор танилцуулж, тэдгээрийн саналыг авч тайланд тусгаж ажиллаж байна. Энэхүү биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгааллын стратегийн хүрээнд төлөвлөгөө, хөтөлбөрийг орон нутгийн захиргааны саналыг тусгаж хэрэгжүүлэх ёстой.

Тус төслийн хувьд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр орон нутагтай ажил гүйцэтгэх №СЭ-24/01 дугаартай гэрээг байгуулсан ба уг гэрээгээр “ЗУУБ” ХХК нь “Ар, Өвөр гахайтын” агнуурын бүс нутагт шилжин нутаглаж байгаа зэрлэг амьтдад тэр дундаа уулын туурайтан, нэн ховор амьтдын тархац бүс нутгийг тэлэх, болзошгүй аюул, эрсдэлээс хамгаалах зорилгоор биотехникийн арга хэмжээнд шаардагдах хужир, шүү, өвсийг 2'000'000.0 (Хоёр сая төгрөг)-өөр авч өгөхөөр гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
-	1	2	3	4	5	6	7	8
1.	Дүйцүүлэн хамгаалалт	Биотехникийн арга хэмжээ	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үүнд зэрлэг амьтдад жил бүрийн өвлийн улиралд орон нутаг болон мэргэжлийн байгууллагатай хамтран өвч тэжээл, хужир мараа, мөс тавьж өгөх.	1	2'000.0	2'000.0	2025 онд	-
-	Нийт	-	-	-	-	2'000.0	-	-

4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайн ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх болон ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх шаардлагатай зүйлс байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй болно.

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг зохион байгуулсан болно. Гэрээ болон тайлангийн дүгнэлтийг батлагдсан БОННУ-ний тайланд хавсаргаж оруулсан байна.

4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“ЗУУБ” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Ажилчдад ХАБЭА-ны ажлын хувцас, малгай, хошуувч, гутал	Уурхайн бүх ажилчдад	-	Дотоод төсөвд тусгасан		Өдөр бүр, тогтмол	- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, - Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
2		Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, гал унтраах урьдчилан сэргийлэх тоноглолуудыг бэлдэх, зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад		2'000.0	2'000.0	Сургалтыг улирал бүрт 1 удаа	
3		Химийн бодис, эмнэлгийн хог хаягдал, бензин ШТМ алдагдах үед сэргийлэх SPILL KIT асгаралтын иж бүрдэл байршуулах	Уурхайн ШТС, Уурхайн эмнэлэг, Уурхайн засварын газар	-	Дотоод төсөв	Дотоод төсөв-	Жил бүр	
-	Нийт				-	2'000.0	-	-

4.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаяглын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас үүдэлтэй хүрээлэн буй орчны бохирдол үүсэхээс сэргийлсэн арга хэмжээнүүдийг гүйцэтгэнэ.

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлын бохирдол үүсэх	Энгийн хог хаягдалыг ангилан ялгаж хэвших, сар бүр гэрээний дагуу сумын ТҮК-ээр ачуулах,	Хог хаягдлын аж ахуйн түр хадгалах цэг	-	400.0	-	400.0	Сар бүр	-Хог хаягдлын тухай хууль (2017.05.12)
2		Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр нийлүүлэх	Хог хаягдлын аж ахуйн түр хадгалах цэг	-	600.0	-	600.0	Жил бүр	
3		Гал тогооны хоолны үлдэгдэл хог хаягдлыг дахин боловсруулж бордоо болгон ашиглах эсвэл малчдын нохойн хоол, гахайн фермерт нийлүүлэх	Кемп	-	-	-	-	Сар бүр	
4		“Хог хаягдлын тухай хуулийн 11.3-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахимаар болон цаасан хэлбэрээр энгийн хог хаягдлын мэдээ тайланг харьяалах сумын Засаг дарга, аюултай хог хаягдлын мэдээ тайланг харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх”	Төслийн талбай	-	-	-	-	Жил бүр	БОАЖСайдын 2018 оны А/428 дугаар тушаалаар баталсан “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
5		Үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн аймаг, сум руу тайлангаа гаргаж харьяа сум, аймагт хүргүүлэх	Төслийн талбай	-	-	-	-	Жил бүр	
-	Нийт			-	1'000.0	-	1'000.0	-	-

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“ЗУУБ” ХХК-ний элс, хайрганы ордыг ашиглах үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“ЗУУБ” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO) шинжилгээ хийлгэж байх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох	Агаарын найрлага: 7 сард	1	200.0	200,000	Итгэмжлэгдсэн лабораторт агаарын сорьц шинжилгээг шинжлүүлэх	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,
2	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тоосны хяналт: - Олборлолтын талбайд, -Хүнд даацын машины дотоод замд	6, 9 саруудад	1	200.0	200,000		-MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга

	Дуу шуугиан, чичиргээ: -Хүнд даацын машины тээврийн зам, -Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим	-Хүнд даацын машины дотоод замд, -Үйлдвэрийн талбайд	6, 9 саруудад	1	100.0	100,000		-MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотокolorиметрийн арга,
Усны хяналт шинжилгээ								
1	Усны ерөнхий химийн шинжилгээ: pH, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ - ны агууламж, амт, үнэр, өнгө.	- Унд ахуйн усыг хангаж буй 2 худаг, Шүүрлийн ус, бохир цэвэршүүлэгчийн оролт, гаралтын усыг, ойролцоох гадаргын усыг	Жилд 1 удаа 7 сард -шүүрлийн ус оролт, -шүүрлийн ус гаралт -ундны ус оролт -ундны ус гаралт -бохир	1	-	500.0	Усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх.	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж, -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 13.060.50 Усны чанарын стандарт -MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
Хөрсний бохирдол								
3.1	Хөрсний химийн болон физик үндсэн шинж чанар: (Ялзмаг, урвалын орчин, карбонат, нитрат, фосфор, кали, давсжилт, чулуужилт, механик бүрэлдэхүүн, эзлэхүүн жин зэрэг үзүүлэлтүүд)	Төслийн талбайд 2 цэг сонгох (Овоолго болон олборлолт явуулж буй талбайн ойролцоо)	Жилд 1 удаа 7-р сард	1	-	100.0	Хөрсний итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга

	-Хөрсний хүнд металл: кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр.							-MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
Ургамлын бүрхэвч болон Амьтны аймаг								
4.1	Мэргэжлийн байгууллага болон судлаачаар мониторинг хийлгэх	Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүсэд	7-8-р сарын хооронд	Дотоод төсөв			-	-
	Нийт			-	-	1'000,000.0	-	

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“ЗУУБ” ХХК-ний элс, хайрганы ордыг ашиглах үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Байгаль орчны асуудалд зөвхөн байгаль орчны мэргэжилтэн анхаарал хандуулах биш уурхай болон үйлдвэрийн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүнд:

- ✓ Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- ✓ Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- ✓ Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана,
- ✓ Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 17. Тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 онд				
			4-6-р сар	7-9-р сар	10-11-р сар		
1	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	“ЗУУБ” ХХК	Байгаль орчны мэргэжлийн ажилтан уурхайд байх шаардлагатай.
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	+			Уурхайн удирдлага	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн ажиллах шаардлагатай.
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Тогтмол			Уурхайн удирдлага	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах шаардлагатай.
4	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
5	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хамтран ажиллах	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	+	+	+	“ЗУУБ” ХХК	Орон нутагтай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтарч ажиллах.
Нийт		-	-		-	-	-

4.11. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

"ЗУУБ" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 18. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Аймгийн байгаль орчны газар, БОУАӨЯ	Багийн ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Багийн төв
	Аймгийн БОГ, БОХХБайцаагч	Уулзалт			Аймгийн төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОУАӨЯ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2025 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

4.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

“ЗУУБ” ХХК-ийн 2025 оны БОМТ-г БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2025 онд БОМТ-нд нийт 8,600,000.0 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө

Хүснэгт 19. Төслийн 2025 оны БОМТ-ний зардлын нэгтгэл

№	Арга хэмжээ	Зардал' төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2'600'000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2'000'000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	Дотоод төсөв
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Хийгдсэн
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2'000'000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1'000'000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1'000'000.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
-	Нийт дүн	8'600'000.0

ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших “ЗУУБ” ХХК-ийн “Гурван салаа” нэртэй элс, хайрганы уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Элс, хайрга олборлох үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын гадарга ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг жил бүрийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллах шаардлагатай.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 8'600'000.0 (Найман сая зургаан зуум мянга) төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“ЗУУБ” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал дахь нөхөн сэргээлтийн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

2025 оны Нөхөн сэргээлтийн нийт зардлын 50% буюу **4'300'000.0 төгрөг (Дөрвөн сая гурван зуун мянга) төгрөгийг БОАЖА-ы тусгай дансанд байршууллаа.**

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, Сэлэнгэ аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn
3. Байгаль орчны мэдээллийн сан: www.eic.mn